

CURRENT STATE AND EMERGING CHALLENGES IN THE AUDIT SECTOR OF MONGOLIA

Bayalag Ganbaatar^I, Altan-Erdene Batbayar^{II}

Abstract: This study aims to evaluate the current state of the audit sector in Mongolia and identify the key factors affecting audit quality. The research framework is based on three core dimensions: input (auditor's knowledge, experience, and ethics), process (quality control and independence), and output (usefulness and reliability of audit reports). Using a qualitative survey method, 70 professional auditors were surveyed. The findings highlight that factors such as audit team competence, quality control systems, and auditor independence have the strongest influence on audit quality. The study proposes recommendations to improve institutional support and strengthen national audit firms' capacity.

Keywords: audit, audit quality, quality control, independence, professional services

АУДИТЫН ЧАНАРТ НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛС БА ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУД

Хураангуй: Энэхүү судалгаагаар Монгол Улсын аудитын салбарын өнөөгийн нөхцөл байдлыг олон өнцгөөс үнэлж, аудитын үйлчилгээний чанарт нөлөөлж буй гол хүчин зүйлсийг тодорхойлохыг зорьсон. Судалгаанд орц (аудиторын мэдлэг, туршлага, ёс зүй), үйл явц (чанарын хяналт, хараат бус байдал), гарц (аудитын тайлангийн хэрэглээ, хэрэглэгчийн сэтгэл ханамж) гэсэн үндсэн чиглэлд суурилсан үнэлгээг хийсэн. Чанарын судалгааны аргаар асуулгын анкет боловсруулж, 70 аудиторос мэдээлэл цуглуулсан бөгөөд үр дүнд хамгийн өндөр нөлөөтэй хүчин зүйлсийг тодорхойлсон. Судалгааны үр дүнгээр аудитын багийн чадавхи, чанарын хяналтын тогтолцоо, хараат бус байдал зэрэг хүчин зүйлс зонхилон нөлөөлж буйг тогтоосон бөгөөд үндэсний аудитын компаниудын чадавхийг нэмэгдүүлэх, мэргэжлийн байгууллагын дэмжлэгийг сайжруулах зэрэг санал, зөвлөмж гаргасан.

Түлхүүр үгс: аудит, аудитын чанар, чанарын хяналт, хараат бус байдал, мэргэжлийн үйлчилгээ

^I Business School, National University of Mongolia, (E-mail): bayalag1979@gmail.com

^{II} Business School, National University of Mongolia, (E-mail): altanerdene.b@num.edu.mn

Удиртгал

Аудитын үйлчилгээ нь бизнесийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, оролцогч талуудын итгэлцлийг бий болгох, санхүүгийн тайлагналын үнэн зөв, бодит байдлыг баталгаажуулахад чухал үүрэг гүйцэтгэдэг мэргэжлийн өндөр хариуцлагатай, хууль эрх зүй, ёс зүй, стандартын нарийн зохицуулалт бүхий үйл ажиллагааны төрөл юм. Аудитын чанартай үйлчилгээ нь зөвхөн нэг компанийн бус, нийт эдийн засгийн санхүүгийн сахилга бат, засаглалд эерэгээр нөлөөлдөг.

Гэвч сүүлийн жилүүдэд Монгол Улсад аудитын үйлчилгээний чанар, хүртээмж, хяналт, хүний нөөц, зах зээлийн бүтэц зэрэг олон хүчин зүйлсийн хүрээнд тулгамдсан асуудлууд хуримтлагдсаар байгаа нь мэргэжлийн байгууллагуудын анхаарлыг татах болсон. Аудитын үйлчилгээний үнэ, чанарын тэнцвэрт байдал алдагдах, “тамганы аудит” гэх ойлголт дэлгэрэх, хүний нөөцийн хомсдол, чанарын хяналтын тогтолцооны сул тал зэрэг нь салбарын хөгжлийг сааруулж байна.

Энэхүү судалгаагаар аудитын салбарын өнөөгийн нөхцөл байдлыг олон өнцгөөс шинжилж, чанарт нөлөөлж буй гол хүчин зүйлсийг тодорхойлох, салбарын хөгжлийг дэмжих арга замыг санал болгох зорилготой. Судалгаанд аудитын чанарт нөлөөлдөг орц (аудиторын мэдлэг, туршлага, ёс зүй), үйл явц (чанарын хяналт, хараат бус байдал, дотоод зохион байгуулалт), гарц (аудитын тайлангийн чанар, хэрэглэгчийн сэтгэл ханамж) гэсэн голлох хүчин зүйлсийг үнэлсэн болно.

Судалгааны хүрээнд анкетын судалгаа, салбарын хоёрдогч мэдээлэл, статистик үзүүлэлтүүдэд тулгуурлан дүн шинжилгээ хийж, дүгнэлт гаргасан бөгөөд үндэсний аудитын компаниудын чанарын хяналтын тогтолцоо, мэргэжлийн байгууллагуудын оролцоо, хууль эрх зүйн зохицуулалтын хүрээнд сайжруулах шаардлагатай асуудлуудыг тодорхойлсон. Судалгааны үр дүнд тулгуурлан санал, зөвлөмж боловсруулж, цаашдын бодлого боловсруулахад хувь нэмэр оруулахыг зорьсон болно.

Аудитын чанарын талаарх судалгаа нь олон улсын эрдэмтдийн дунд өргөн хүрээнд хийгдэж ирсэн. DeAngelo (1981) анх аудитын чанарыг аудитын компанийн хэмжээ, аудиторын туршлагатай уялдуулан авч үзсэн бөгөөд компани том байх тусам хараат бус байдал болон аудитын чанар сайн байх магадлалтайг онцолжээ. Түүнчлэн Francis (2004, 2009) нь аудитын чанарт нөлөөлдөг хүчин зүйлсийг томоохон аудитын компаниудын бүтэц, чанарын хяналтын тогтолцоо, аудитын багийн зохион байгуулалттай холбон тайлбарласан байдаг.

Choi нар (2010) болон Rajgoral нар (2021) аудитын чанарын гол нөлөөлөгч хүчин зүйлс нь аудиторын хараат бус байдал, ёс зүй болон хэрэглэгчийн итгэлцэлтэй холбоотойг тэмдэглэсэн. Мөн Beisland (2012), Lin & Hwang (2010) нар компанийн сайн засаглал нь аудитын чанарт шууд нөлөөлдөг болохыг тогтоожээ.

Монголын нөхцөлд аудитын чанар, аудитын байгууллагын бүтэц, хэрэглэгчийн ойлголт, нягтлан бодох бүртгэлийн орчин зэрэг асуудлыг судалсан судлаачид цөөнгүй. Тухайлбал, Мөнх-Очир & Өнөржаргал (2016) нь Монгол Улсад олон улсын

стандартуудын хэрэгжилт хангалтгүй байгааг нягтлан бодох бүртгэлийн зардал, хүний нөөцийн чадавхиар тайлбарласан. Гантулга (2017) санхүүгийн тайлангийн мэдээллийн чанар нь аудитын үр дүнд шууд нөлөөлдөг болохыг онцолсон бол Цэнд-Аюуш (2012), Дондог (2017) нар компанийн засаглалын сул орчны улмаас хэрэглэгчид аудитын тайланг хангалттай үнэлж хэрэглэдэггүй хандлагыг дурдсан байна.

Түүнчлэн ММНБИ-ийн тайланд аудитын зах зээлийн өрсөлдөөн нь хэт бага үнийн стратегид тулгуурлаж, үйлчилгээний чанарыг бууруулах эрсдэлтэйг анхааруулсан. Давааням (2024) аудитын компанийн хүний нөөцийн ачааллыг онцолж, нэг аудитор ногдох харилцагчийн дундаж тоо олон улсын жишгээс давж байгааг судалгаагаар харуулсан байна.

Дээр дурдсан судалгаанууд аудитын чанарт нөлөөлөх гол хүчин зүйлсийг орц, үйл явц, гарц гэсэн чиглэлд нэгтгэн авч үзэх онолын суурь болсон бөгөөд энэхүү судалгааны хүрээнд дээрх ангилалд тулгуурлан үнэлгээг хийсэн болно.

Судалгааны аргачлал

Энэхүү судалгааны үндсэн зорилго нь Монгол Улсын аудитын салбарын өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлуудыг системтэйгээр тодорхойлж, цаашдын хөгжлийн чиг хандлагад бодитой үнэлгээ өгөхөд оршино. Судалгаанд аудитын салбарт нөлөөлж буй хүчин зүйлсийг онолын хүрээнд ангилан, практик туршлагад тулгуурлан дүн шинжилгээ хийхийн тулд чанарын судалгааны аргыг ашигласан болно.

Судалгааны аргазүйн хувьд дараах үе шаттайгаар судалгааг хэрэгжүүлсэн. Нэгдүгээрт, аудитын салбарын онолын суурь ойлголт, олон улсын чиг хандлага, хууль эрх зүйн орчны талаар хоёрдогч эх сурвалжид тулгуурлан шинжилгээ хийв. Хоёрдугаарт, аудитын салбарын орчин, үйл ажиллагаа, хүний нөөц, чанарын хяналтын тогтолцоо зэрэг гол үзүүлэлтийг тусгасан асуулгын анкет боловсруулж, салбарын төлөөлөл болсон аудиторуудаас мэдээлэл цуглуулсан.

Анкетын судалгаа нь 26 асуултаас бүрдэж, Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй аудитын компаниудад ажиллаж буй 70 аудитор оролцсон. Судалгаанд оролцогчдыг санамсаргүй түүврийн аргаар сонгосон бөгөөд түүврийн хэмжээ нь 90 хувийн итгэлцлийн түвшинд статистикийн дүгнэлт хийх боломжийг бүрдүүлж байна. Судалгаанд хамрагдсан аудиторуудад боловсруулсан асуулгыг цахим болон биечлэн хүргүүлж, мэдээлэл цуглуулсан бөгөөд нийт хариу ирүүлсэн хувь өндөр байсан.

Анкетын агуулга нь аудитын чанарт нөлөөлдөг хүчин зүйлсийг онолын үндэслэлд тулгуурлан “орц” (input), “үйл явц” (process), “гарц” (output) гэсэн үндсэн гурван бүлэгт хуваан үнэлгээг хийсэн. Үүнд аудиторын мэдлэг, туршлага, ур чадвар, хандлага, ёс зүй, хараат бус байдал, чанарын хяналтын тогтолцоо, аудитын багийн зан төлөв, орчин үеийн мэдээллийн технологийн хэрэглээ зэрэг үзүүлэлтүүд багтсан. Анкетын хариултыг SPSS болон Excel программын тусламжтайгаар боловсруулж, тухайн хүчин зүйл бүрт ногдох хувь хэмжээ, давтамж, дундаж үзүүлэлт, стандарт хазайлт зэрэг статистик хэмжигдэхүүнүүдийг тооцоолсон. Ингэснээр аудитын чанарт хамгийн их

нөлөөтэй хүчин зүйлсийг тодорхойлж, тэдгээрийн харьцангуй нөлөөллийг үнэлэх боломж бүрдсэн.

Ингэж судалгааны аргазүйн нарийвчилсан үндэслэл, системтэй түүвэрлэлт, асуулгын судалгаа, өгөгдөл боловсруулах аргачлалыг ашиглан бодит мэдээлэлд тулгуурласан үр дүнг гаргаж, аудитын салбарын өнөөгийн байдлыг олон талт өнцгөөс үнэлэхийг зорьсон болно.


Судалгааны үр дүн

Судалгаанд хамрагдсан 70 аудиторын хариултад дүн шинжилгээ хийхэд дараах үр дүн гарсан. Судалгаанд оролцогчдын 83.1 хувь нь мэргэшсэн аудитор, 70.4 хувь нь аудитын компанийн захирлын албан тушаал хашиж байгаа нь тэдний туршлагын түвшинг илтгэж байна. Насны хувьд оролцогчдын 29.6 хувь нь 36-45 насны, 28.2 хувь нь 46-55 насны, 25.4 хувь нь 55-аас дээш насныхан байв.

Аудитын чанарт нөлөөлдөг хүчин зүйлсийн дунд “орцын хүчин зүйл” буюу аудиторын мэдлэг, туршлага, ур чадвар, ажил гүйцэтгэх хугацаа, компанийн соёл зэрэг үзүүлэлтүүд хамгийн өндөр үнэлгээтэй гарсан байна. Эдгээр үр дүнг доорх Зураг 1-д үзүүлэв.

Зураг 1. Аудитын чанарт нөлөөлөх орцын хүчин зүйлсийн дундаж үнэлгээ


5. Таны бодлоор санхүүгийн тайлангийн аудитыг чанартай гүйцэтгэхэд дараах хүчин зүйлүүд ямар нөлөөтэй байдаг вэ?



Үйл явцын хүчин зүйлсийн хувьд салбарын хууль эрх зүйн орчин, аудиторын үл итгэх үзэл, цаг хугацаа болон төсвийн хязгаарлалт зэрэг нь хамгийн ихээр нөлөөлж буйг харуулсан (Зураг 2).

Зураг 2. Аудитын чанарт нөлөөлөх үйл явцын хүчин зүйлсийн үнэлгээ


6. Таны бодлоор санхүүгийн тайлангийн аудитыг чанартай гүйцэтгэхэд дараах хүчин зүйлүүд ямар нөлөөтэй байдаг вэ?



Харин гарцын хүчин зүйлсийн хувьд аудитын үр дүнд боловсруулсан тайланд хэрэглэгчийн сэтгэл ханамж хамгийн гол үзүүлэлт болж байна (Зураг 3).

Зураг 3. Аудитын гарцын хүчин зүйлсийн үнэлгээ

7. Таны бодлоор санхүүгийн тайлангийн аудитыг чанартай гүйцэтгэхэд дараах хүчин зүйлүүд ямар нөлөөтэй байдаг вэ?



Судалгааны үр дүнд үндэслэн хамгийн их оноо авсан таван хүчин зүйлийг нэгтгэн харахад (Хүснэгт 1) аудитын чанарт “үйл явцын хүчин зүйлс” зонхилон нөлөөлж байгааг онцлох нь зүйтэй. Энэ нь олон улсын судалгааны үр дүнтэй нийцэж буй бөгөөд тухайлбал Francis (2004), Choi нар (2010), Rajgoral нар (2021)-ын судалгаанд аудитын чанарт аудитын багийн дотоод зохион байгуулалт, хараат бус байдал, хяналтын тогтолцоо чухал нөлөөтэй гэж үздэг.

Хүснэгт 1. Аудитын чанарт хамгийн их нөлөөлөх таван хүчин зүйл

№	Хүчин зүйлс	Ангилал
1	Аудиторын мэдлэг, туршлага, ур чадвар	Орц
2	Чанарын хяналтын систем	Үйл явц
3	Аудиторын үнэт зүйл, ёс зүй, хандлага	Орц
4	Аудиторын хараат бус байдал	Үйл явц
5	Аудитын багийн зан төлөв хандлага, орчин үеийн мэдээллийн технологи ашиглалт	Үйл явц

Эх сурвалж: Анкетын судалгаанд үндэслэсэн судлаачийн нэгтгэл

Аудитын чанарт хамгийн их нөлөө үзүүлж буй хүчин зүйлс нь аудиторын мэдлэг, туршлага, ур чадвар; чанарын хяналтын систем; аудиторын ёс зүй, хандлага; хараат бус байдал; мөн аудитын багийн хамтын ажиллагаа ба мэдээллийн технологийн ашиглалт байгаа бөгөөд бусад судлаачдын үр дүнтэй харьцуулахад (Хүснэгт 2) аудиторын мэдлэг, туршлага, ур чадвар; аудиторын үнэт зүйл, ёс зүй, хандлага; аудиторын хараат бус байдал нь давхцаж байна.

Хүснэгт 2. Аудитын чанарт нөлөөлөгч хүчин зүйлийн харьцуулсан судалгаа

№	Хүчин зүйлс	Аудитор	Нийт хувь
1	Аудиторын мэдлэг, туршлага, ур чадвар	17%	19%
2	Аудиторын шударга, бие даасан байдал	11%	17%
3	Аудитын үйлчилгээний хөлс		14%

4	Аудитын компанийн нэр хүнд	9%	12%
5	Аудиторын мэргэшсэн байдал (салбарт)	12%	6%

Эх сурвалж: Дамдиндорж (2019)

Аудитын компанийн чадварлаг боловсон хүчний нөөцийн хомсдол, нэг аудиторын ачаалал хэт өндөр байгаа нь чанарт сөргөөр нөлөөлж болзошгүйг өмнөх хэсэгт дурдсан. Үүнийг Хүснэгт 3-д харуулсан хүний нөөцийн ачааллын статистик мэдээллүүд бататгаж байна.

Хүснэгт 3. Хүний нөөцийн ачаалал – нэг аудиторт ногдох харилцагчийн тоо

Статистик	Нэг аудиторт ногдох хувийн хэвшлийн компанийн тоо		Нэг ажилтанд ногдох хувийн хэвшлийн компанийн тоо	
	2022 он	2023 он	2022 он	2023 он
Дундаж	17.22	20.12	10.56	12.12
Медиан	11.73	14.83	7.50	8.33
Моод	7.75	3.00	0.00	2.00
Стандарт хазайлт	18.74	18.16	12.17	11.34
Хамгийн бага	0.00	0.25	0.00	0.20
Хамгийн их	106.25	90.00	85.00	64.00
Нийлбэр	2,324.35	2,836.89	1,425.65	1,709.06
Тоо	135.00	141.00	135.00	141.00


Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Нөгөөтэйгүүр, аудитын үйлчилгээний төлбөрийн бодлого нь хэт өрсөлдөөнд тулгуурласан буюу “тамганы аудит” нэршилд хүрч болзошгүй эрсдэл дагуулж байна. Тус нөхцөл байдлыг судалгаанд оролцогчдын үнэлгээнээс харахад (Зураг 4) аудитын нэр хүндийг унагах гол хүчин зүйлсийн нэг хэмээн тодорхойлсон.

Зураг 4. Аудитын салбарт тулгамдаж буй чухал асуудлуудын үнэлгээ

22. Таны бодлоор аудитын салбарт тулгамдаж буй хамгийн чухал асуудал юу вэ? (олон хариулт сонгож болно)

71 responses




Үүний зэрэгцээ судалгаанд оролцогчид аудитын нэр хүндийг дээшлүүлэх, үндэсний аудитын компаниудыг чадавхжуулах гол шийдэл нь чанарын хяналтын тогтолцоог сайжруулах, мэргэжлийн байгууллагын дэмжлэгийг нэмэгдүүлэх, аудитын үр дүнг үнэлдэг хэрэглэгчийн оролцоог нэмэгдүүлэх хэмээн үзсэн. Эдгээр санал, хүлээлтийг Зураг 5-д үзүүлэв.

Зураг 5. Аудитын нэр хүндийг дээшлүүлэх арга замуудын үнэлгээ

23. Таны бодлоор цаашид аудитын үйлчилгээний нэр хүндийг өсгөх, үндэсний компаниудыг чадавхжуулахад нэн тэргүүнд хийх ёстой зүйл юу вэ? (олон хариулт сонгож болно)

71 responses



Иймд манай судалгааны үр дүнгээс гарч буй дараах гурван үндсэн санал дэвшүүлж байна. Үүнд:

- Аудитын чанарын хяналтын тогтолцоог компанийн болон үндэсний түвшинд боловсронгуй болгох;
- Аудитын багийн хараат бус байдал, хамтын ажиллагааг бэхжүүлэх хөшүүрэг, орчныг бүрдүүлэх;
- Аудитын мэргэжлийн байгууллагуудын арга зүйн дэмжлэг, бодлогын оролцоог эрчимжүүлэх.

Эдгээр санал, дүгнэлт нь зөвхөн судалгаанд оролцогчдоос авсан өгөгдөлд тулгуурлаад зогсохгүй, олон улсын шилдэг туршлага, өмнөх судалгааны үндэслэлтэй уялдуулсан, бодлогын түвшинд авч үзэхүүнд ач холбогдолтой юм.

Дүгнэлт

Монгол Улсын аудитын салбар нь сүүлийн жилүүдэд тогтвортой өсөлттэй хэдий ч чанар, зохион байгуулалт, хариуцлагын түвшинд олон төрлийн тулгамдсан асуудал байгааг судалгааны үр дүн илтгэж байна. Тус судалгааны хүрээнд аудитын чанарт хамгийн ихээр нөлөөлж буй хүчин зүйлс нь:

- Аудиторын мэдлэг, туршлага, ур чадвар;
- Чанарын хяналтын системийн бүрдэл, хэрэгжилт;
- Аудиторын ёс зүй, хандлага, хараат бус байдал;
- Аудитын багийн харилцаа, хамтын ажиллагаа;
- Орчин үеийн мэдээллийн технологийн ашиглалт байв.

Мөн хүний нөөцийн хэт ачаалал, аудитын үйлчилгээний үнэ ханшийн хэт өрсөлдөөн, хэрэглэгчийн ойлголт, итгэлийн асуудал зэргийг анхаарах шаардлагатай болох нь судалгаагаар тодорхой болсон. Зах зээлд “тамганы аудит” гэх ойлголт газар авч, аудитын чанарт сөрөг нөлөө үзүүлж буйг мэргэжлийн түвшинд зогсоох арга хэмжээ авах шаардлагатай байна.

Судалгааны үр дүнд үндэслэн аудитын үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, тогтвортой байдлыг хангахын тулд хэд хэдэн чиглэлээр бодлогын түвшинд анхаарал хандуулах шаардлагатай байна. Нэгдүгээрт, чанарын хяналтын тогтолцоог боловсронгуй болгох нь чухал бөгөөд үүний тулд Сангийн сайдын 2019 оны 60 дугаар тушаалаар батлагдсан “Аудитын хуулийн этгээдэд хийх чанарын хяналтын журам”-ыг олон улсын стандартуудтай нийцүүлэн шинэчлэх шаардлагатай. Мөн аудитын компаниудын түвшинд дотоод чанарын хяналтын бодлого, хариуцлагын тогтолцоог сайжруулах нь чанарт эерэгээр нөлөөлнө.

Хоёрдугаарт, аудитын хараат бус байдлыг хангах хуулийн болон институцийн орчныг илүү тодорхой болгож, хувийн ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллах нөхцөлийг бүрдүүлэх зохицуулалтыг бэхжүүлэх хэрэгтэй. Энэ хүрээнд аудитын практикт хөндлөнгийн хяналтыг тогтмол хэрэгжүүлэх, мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг чанд мөрдүүлэх нь зохистой.

Гуравдугаарт, мэргэжлийн байгууллагуудын оролцоо, нөлөөллийг нэмэгдүүлэх нь салбарын хөгжилд чухал нөлөө үзүүлнэ. Тухайлбал, ММНБИ зэрэг мэргэжлийн байгууллагуудаас үзүүлэх арга зүйн дэмжлэг, сургалтын хамрах хүрээг өргөтгөх, мөн аудитын компаниудын үнэлгээ, ангиллын тогтолцоог бүрдүүлэх замаар салбарын тогтвортой өсөлтийг дэмжих боломжтой.

Дөрөвдүгээрт, хүний нөөцийн тогтвортой байдлыг хангаж, мэргэжлийн ур чадварыг сайжруулах чиглэлд анхаарах нь зүйтэй. Аудитор бэлтгэх тогтолцоог эргэн харж, залгамж халааг оновчтой төлөвлөх, мөн ахмад боловсон хүчнийг орлох чадварлаг залуу мэргэжилтнүүдийг бодлогоор дэмжих шаардлагатай байна.

Тавдугаарт, аудитын үр дүнг бодитой ашиглах нөхцөлийг бүрдүүлэхийн тулд аудитын тайланг үнэлдэг хэрэглэгч талуудын мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах, төрийн захиалгатай аудитын ажлуудад тавигдах чанарын шалгуурыг өндөрсгөх нь зүйтэй юм.

Дээрх зөвлөмжүүдийг хэрэгжүүлснээр аудитын салбарын нэр хүнд, чанар, хэрэглээний үнэ цэнэ нэмэгдэж, санхүүгийн тайлагналын орчны итгэлцэл бэхжих суурь нөхцөл бүрдэх боломжтой.

Ашигласан материал

- Beisland, L. A., Mersland, R., & Strøm, R. III. (2012). Audit Quality and Corporate Governance: Evidence from the Microfinance Industry. *SSRN Electronic Journal*, 19(3). <http://dx.doi.org/10.2139/ssrn.2182485>
- Choi, J.-H., Kim, C., Kim, J.-B., & Zang, Y. (2010). Audit Office Size, Audit Quality, and Audit Pricing. *Auditing: A Journal of Practice & Theory*, 29(1), 73-97. <https://doi.org/10.2308/aud.2010.29.1.73>
- DeAngelo, L. E. (1981). Auditor Size and Audit Quality. *Journal of Accounting and Economics*, 3(3), 183-199. [https://doi.org/10.1016/0165-4101\(81\)90002-1](https://doi.org/10.1016/0165-4101(81)90002-1)
- Eulerich, M., Masli, A., Pickerd, J. & Wood, D. A. (2023). The Impact of Audit Technology on Audit Task Outcomes: Evidence for Technology-Based Audit Techniques. *Contemporary Accounting Research*, 40(2), 981-1012. <https://doi.org/10.1111/1911-3846.12847>
- Francis, J. R. (2004). What Do We Know About Audit Quality? *The British Accounting Review*, 36(4), 345-368. <https://doi.org/10.1016/j.bar.2004.09.003>
- Francis, J. R. & Yu, M. D. (2009). Big 4 Office Size and Audit Quality. *The Accounting Review*, 84(5), 1521-1552. <https://doi.org/10.2308/accr.2009.84.5.1521>
- Lin, J. W. & Hwang, M. (2010). Audit Quality, Corporate Governance, and Earnings Management: A Meta-Analysis. *International Journal of Auditing*, 14(1), 57-77. <http://dx.doi.org/10.1111/j.1099-1123.2009.00403.x>
- Rajgopal, S., Srinivasan, S., & Zheng, X. (2021). Measuring Audit Quality. *Review of Accounting Studies*, 26, 559-619.
- Гантулга, Г. (2017). Санхүүгийн тайлангийн мэдээллийн чанар, түүнийг хэмжих нь. *Бизнес ба Инноваци*, 3(3), 133-147.
- Давааням, М. (2024). Аудитын салбарын үйл ажиллагаа 2024 онд. Жилийн тайлан. Улаанбаатар: ММНБИ.
- Дондог, Л. (2017). СТОУС-ын нэвтрэлтийг цэгнэхүй. *Нягтлан бодох бүртгэлийн онол, практик*, 1(1), 1-11.
- Жааваа, Т. (2003). Монгол Улсын нягтлан бодох бүртгэлийн тогтолцооны шинэчлэлийн зарим асуудал. Монограф, Улаанбаатар: МУИС-ийн хэвлэл.
- ММНБИ (2022). Өртөг ба гүйцэтгэлийн удирдлага. Сурах бичиг. Улаанбаатар.
- Мөнх-Очир, Л. & Өнөржаргал, А. (2016). Манай улсын нягтлан бодох бүртгэлийн шинэчлэл, эрх зүйн орчны төлөвшил. *Бизнес ба Инноваци*, 2(3), 85-98.
- Өнөржаргал, А. (2017). Монгол Улсын нягтлан бодох бүртгэлийн шинэчлэл. *Нягтлан бодох бүртгэлийн онол, практик*, 1(1), 13-21.
- Цэнд-Аюуш, Т. (2012). Монгол Улсын компанийн засаглалыг сайжруулах арга замууд. Докторын диссертаци. Улаанбаатар: ШУТИС.